

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭМДЭГЛЭЛ**

2021.04.27

дугаар 01

Улаанбаатар хот

“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 4 дүгээр сарын 27 -ны өдрийн 13 цагаас 14 цагийн хооронд ZOOM программаар цахимаар хуралдav.

Хурлын эхэнд Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож буй оролцогчдын ирцийг тооллогын комисс нэгтгэн гаргаж “хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай” ХЭХ-ын тооллогын комиссын 01 дүгээр тогтоолыг комиссын дарга /Г.Өүлэн/ уншиж танилцуулав.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд нийт 10,170,242 ширхэг саналын эрхтэй хувьцааг төлөөлж 9,026,174 ширхэг энгийн хувьцаа эзэмшигч буюу 88.7 хувь нь хуралд ирснийг мэдээлж, компанийн тухай хуулийн 69,1 дэх заалт, компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журмын 4-ийн 7 дахь заалтын дагуу энэхүү ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсоныг уг тогтоолд дурьдсан байна.

**Хурлын дарга** – Хуралд ирсэн хувьцаа эзэмшигч та бүхэнд баярласнаа илэрхийлье. Хурлын ирц хуульд заасан хэмжээнд хүрч байгаа тул хурлын үйл ажиллагааг нээж байна. Хурлын хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцууляяа.

**1. ХЭЛЭЛЦСЭН НЬ:** “Компанийн 2020 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх, ТҮЗ-ийн дүгнэлт батлах”

– 2020 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тайланг Үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал Г.Мөнхбат танилцуулна гэв.

**Г.Мөнхбат** – Уг тайланг танилцуулах слайд ашиглан, цахим хурлын дэлгэцэнд үзүүлж дэлгэрэнгүй тайлагнав.

-2020 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн аудитын дүгнэлтийг ерөнхий нягтлан бодогч Л.Эрдэнэжаргал танилцуулна.

**Л.Эрдэнэжаргал** – Компанийн 2020 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг танилцуулах слайд ашиглан, цахим хурлын дэлгэцэнд дэлгэрэнгүй тайлбарлан танилцуулав.

**2. ХЭЛЭЛЦСЭН НЬ:** “Компанийн ТҮЗ-ийн 2021 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах тухай” /холбогдох материалыг хавсаргав/

**Ө.Энхтайван-** Компанийн ТҮЗ-ийн 2021 оны цалин урамшуулал, зардлын төсвийн талаар дэлгэрэнгүй тайлбарлан танилцуулав.

**3. ХЭЛЭЛЦСЭН НЬ:** “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай”

**Ө.Энхтайван-** ТҮЗ-ийн гишүүдийн нэр дэвшигчдийн танилцуулгыг танилцуулах слайд ашиглан дэлгэцэнд үзүүлж танилцуулав.

**Гүйцэтгэх захирал Х.Уянга-** Ногдол ашиг хуваарилах санхүүгийн боломжгүй байсан тухай мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд өгөв.

**Би ди сек УЦК ХХК-ийн төлөөлөгч Б.Даваадорж:** Шарын гол ХК хэдэн охин компанийтай вэ?

**Гүйцэтгэх захирал Х.Уянга-2** охин компанийтай, Нагай ХХК, Гавылуу Уул ХХК гэж нэртэй.

**Би ди сек УЦК ХХК-ийн төлөөлөгч Б.Даваадорж:** 2021 оны төлөвлөгөө юу байгаа вэ?

**Х.Уянга-2020** оны тайлан тавьж байгаа тул 2021 оны төлөвлөгөөний талаар яг нарийн тооцоо судалгаатай гэхээсээ илүү ерөнхий тойм байдлаар мэдээлэл өгнө. Нүүрс олборлолтыг 1,1 сая тонн гэж үзэж байгаа, мөн алтны олборлолт хийнэ. Томоохон ажил хөрөнгө оруулалтын хувьд 1980-аад онд ашиглалтад оруулсан нүүрс ачилтын байгууламжийг шинэчилнэ. Уг байгууламж нь ашиглалтын шаардлага хангахаа бараг болж байгаа 40 жил болсон байдаг. Түүнчлэн хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой хөрөнгө оруулалтууд мэдээж цаг тухай бүрт нь хийгдээд явна.

**Л.Эрдэнэжаргал-Нүүрс** борлуулалтын орлогыг 53 гаруй тэр бум төгрөгөөр тооцоолж байгаа ба үйл ажиллагааны зардал, ашиг алдагдлын талаар тооцоо судалгааны үндсэн дээр гарна байх.

**Монголын жижиг хувьцаа эзэмшигчдийн нэгдсэн холбоо ТББ Б.Содбаатар:** Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангах тал дээр ямар байр суурь баримтлах вэ?

**Х.Уянга-Нээлттэй** хувьцаат компани тул үйл ажиллагаагаа нээлттэй байлгаж, оролцоог нь ханган, мэдээ мэдээллийг цаг тухай бүрт хүргэх байдлаар ажиллана. Ерөнхийдөө жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангах бодлого чиглэлтэй ажиллана.

Хурлын дарга— Асууж, ярилцах, санал бодлоо солилцох талаар ярилцаа үүгээр үндсэн асуудлаа дуусгаад түр завсарлай. Энэ хооронд тооллогын комисс дүнгээ нэгтгэж гаргаад тогтоолоо танилцуулна гэв.

Түр завсарлага 10 минут болов.

Хурлын тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсаарирүүлсэн дүнг нэгтгэсэн тул хурал үргэлжлэв.

Тооллогын комиссын дарга Г.Өэлүн тооллогын комиссын дүн, тогтоолыг танилцуулав..  
Тус хурлаар шийдвэрлэсэн асуудал тус бүрийн зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо хувь, тооллогын комиссын тогтоол дугаар 2, 3 болон кумулятив аргаар тоолсон дүнгийн тогтоол 4-г уншиж танилцуулав. Үүнд:

| д/д | Хэлэлцсэн асуудал  | Санал      |            |            |      | Баталсан шийдвэр                     |
|-----|--|------------|------------|------------|------|--------------------------------------|
|     |  | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн | Хувь |                                      |
| 1   | Компанийн 2020 оны жилийн үйл ажиллагаа, болон санхүүгийн тайлан ТУЗ-ийн дүгнэлт | 9,026,173  |            |            | 100% | Тооллогын комиссын тогтоол Дугаар 02 |
| 2   | Компанийн ТУЗ-ийн 2021 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах.               | 9,026,173  |            |            | 100% | Тооллогын комиссын тогтоол Дугаар 03 |

Тооллогын комиссын тогтооюус асууж танилцах зүйл гарсангүй. /Тооллогын комиссын тогтоол дугаар 02, 03-г хавсаргав/

| I.                      | Компанийн<br>ТУЗ-ийн<br>гишүүдийг<br>сонгох | Санал өгөх<br>эрх | Санал<br>өгсөн эрх | Хувь |
|-------------------------|---|-------------------|--------------------|------|
| a) Ердийн<br>гишүүд     |   |                   |                    |      |
| Б.Батбаатар             | 81,235,557                                  | 8,844,378         | 10.9%              |      |
| Х.Уянга                 | 81,235,557                                  | 8,843,372         | 10.9%              |      |
| Ж.Эрдэнэбат             | 81,235,557                                  | 8,840,872         | 10.9%              |      |
| Б.Итгэл                 | 81,235,557                                  | 8,843,122         | 10.9%              |      |
| Ө.Хишигсүх              | 81,235,557                                  | 65890             | 0.1%               |      |
| Н.Батнайрамдал          | 81,235,557                                  | 8,842,372         | 10.9%              |      |
| Т.Говьдэлгэр            | 81,235,557                                  | 8,775,982         | 10.8%              |      |
| б) Хараат бус<br>гишүүд |   |                   |                    |      |
| Г.Хулан                 | 81,235,557                                  | 8,842,872         | 10.9%              |      |
| О.Цэндсүрэн             | 81,235,557                                  | 8,842,622         | 10.9%              |      |
| М.Батсүрэн              | 81,235,557                                  | 65890             | 0.1%               |      |
| Б.Тулга                 | 81,235,557                                  | 10,428,180        | 12.8%              |      |

Тооллогын комиссын тогтоолоос асууж танилцах зүйл гарсангүй. /Тооллогын комиссын тогтоол дугаар 04-ыг хавсаргав

**ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хэлэлцсэн асуудалтай холбогдуулан гарах тогтоолуудын төслийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ө.Энхтайван уншиж сонгов. Үүнд:

- “Компанийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх, ТУЗ-ийн дүгнэлтийн тухай” тогтоол №01
- “Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны цалин урамшуулал, зардлын төсвийн тухай” тогтоол №02
- “Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай”

Эдгээр тогтоол болно. /тогтоолуудыг хавсаргав/

Хурлаас гарах тогтоолын төслүүдийн талаар асууж тодруулах зүйл байгаа эсэхийг асуу, Хурлын үйл ажиллагааг хаав.

Тэмдэглэл хөтөлсон:

ТУЗ-ийн нарийн бингийн дарга

Ө.Энхтайван

Танилцсан: Хурлын дарга

Г.Хулан



**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 4 сарын 27

дугаар 01

Улаанбаатар хот

Компанийн жилийн үйл ажиллагааны болон  
Санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн  
удирдах зөвлөлийн дүгнэлтийн тухай

“Шарын гол” хувьцаат компанийн 2020 оны жилийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлөөс оруулсан дүгнэлтийг хэлэлцээд,

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ Нь:

1. “Шарын гол” хувьцаат компанийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг баталсугай.



**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 4 сарын 27

дугаар 02

Улаанбаатар хот

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2021 оны цалин урамшуулал, зардлын төсөв  
батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны цалин урамшуулал, зардлын төсвийг /хавсралтаар/ баталсугай.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин урамшууллын хороонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.ХУЛАН





**"Шарын гол" ХК-ийн ТУЗ-ийн 2021 оны зардлын төсөв**

| д/д | Зардлын төрөл                  | (мян.төг)<br>НИЙТ ЗАРДАЛ<br>м.төг |
|-----|--------------------------------|-----------------------------------|
| 1   | ТУЗ-ийн дарга, гишүүдийн цалин | 171,000.0                         |
| 2   | НДШ                            | 23,940.0                          |
|     | <b>ДҮН</b>                     | <b>194,940.0</b>                  |

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2021.04.27

дугаар 03

Улаанбаатар хот

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн  
гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалт, компанийн дүрмийн 8.3 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд

Б.Батбаатар

Х.Уянга

Н.Батнайрамдал

Б.Итгэл

Т.Говьдэлгэр

Ж.Эрдэнэбат

Хараат бус гишүүнд

Г.Хулан

Б.Тулга

О.Цэндсүрэн

нарыг

2021 оны 4 дүгээр сарын 27-ны өдрөөс 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл 2 жилийн хугацаагаар сонгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.ХУЛАН

